

ШУТИС-ИЙН ОЮУТНУУДАД КРЕДИТИЙН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн оюутнуудын нийгмийн идэвхи, оролцоог дээшлүүлэх, тэдний авъяас чадвар, хүсэл сонирхлыг нь урамшуулан дэмжих, хөгжүүлэх зорилгоор сурлага, эрдэм шинжилгээ, урлаг, спортын онцгой амжилт гаргасан шилдэг оюутнуудад урамшуулал олгох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Урамшууллын төрлүүд

2.1 ШУТИС-ийн нэрийн өмнөөс олон улс, улс, бүс нутаг, их дээд сургуулиудын дунд зохиогдож байгаа эрдэм шинжилгээний хурал, олимпиад, спорт, урлагийн уралдаан тэмцээн, наадмуудад холбогдох нэгж, сургууль, захирлын зөвшөөрлийн дагуу амжилттай оролцож эхний гурван байранд шалгарсан, захирлын нэрэмжит хуудсанд бичигдсэн болон оюутнуудын сайн дурын, мэргэжлийн клубүүдийн үйл ажиллагаанд оролцсон байдлыг үнэлэх урамшууллыг оюутнуудад дараах байдлаар олгоно.

(Тэмцээн, уралдааны нэр төрлийг давхцуулан олгохгүй)

2.1.1 Эрдэм шинжилгээний хурал, олимпиад

- Бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжилгээний хурал, олимпиад 2 кр хүртэл
- ШУТИС-ийн эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиад 3 кр хүртэл
- Их, дээд сургуулийн нэгдсэн эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиад 4 кр хүртэл
- Олон улсын эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиад 6 кр хүртэл

2.1.2 Мэргэжлийн уралдаан, тэмцээн

- Бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд зохиогдсон уралдаан тэмцээн 2 кр хүртэл
- ШУТИС-ийн хэмжээний уралдаан тэмцээн 3 кр хүртэл
- Их, дээд сургуулиудын хэмжээний уралдаан тэмцээн 4 кр хүртэл
- Олон улсын хэмжээний уралдаан тэмцээн 6 кр хүртэл

2.1.3 Техник, технологийн чиглэлийн уралдаан, тэмцээн

- ШУТИС-ийн хэмжээнд зохион байгуулагдсан уралдаан, тэмцээн 2 кр хүртэл
- Улс, бүсийн чанартай уралдаан, тэмцээн 4 кр хүртэл
- Олон улсын хэмжээний тэмцээн 6 кр хүртэл

2.1.4 Спортын уралдаан, тэмцээн

- Бүсийн тэмцээн 2 кр хүртэл
- Их, дээд сургуулиудын оюутны тэмцээн 3 кр хүртэл
- Улсын чанартай тэмцээн 4 кр хүртэл
- Олон улсын чанартай тэмцээнд 6 кр хүртэл

2.1.5 Соёл, урлагийн наадам, уралдаан, тэмцээн

- ШУТИС-ийн урлагийн их наадам 2 кр хүртэл
- Бүсийн хэмжээний уралдаан, тэмцээн 3 кр хүртэл
- Улсын хэмжээний уралдаан, тэмцээн 4 кр хүртэл
- Олон улсын хэмжээний соёл, урлагийн уралдаан, тэмцээн 6 кр хүртэл

2.2 ШУТИС-ийн хэмжээнд зохион байгуулагддаг нэгдсэн арга хэмжээ, олон нийтийн үйл ажиллагаанд идэвхитэй, тогтмол оролцдог оюутнууд, сайн дурын болон мэргэжлийн клубүүдийн үйл ажиллагааг дэмжих үүднээс тэдний ажлын үр дүнг харгалзан улиралд нэг удаа урамшуулал олгоно. Үүнд:

- Олон нийтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог оюутнууд 1 кр хүртэл
- Сайн дурын болон мэргэжлийн клубүүдийн ахлагч 2 кр хүртэл
- Клубүүдэд хичээл заадаг оюутнууд 3 кр хүртэл

2.3 ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн захирлын нэрэмжит хуудсанд бичигдсэн, хамт олныхоо дунд нэр хүндтэй, шилдэг оюутанд тухайн бүрэлдэхүүн сургуулийн захирлын нэрэмжит кредитийн урамшууллыг улиралд нэг удаа давхцуулахгүйгээр олгоно. (Бүрэлдэхүүн сургуулиуд нь улирлын үнэлгээний голч дүнгийн минимумыг оюутны сурлагын амжилтаас хамааруулан дээшлүүлж тогтоож болно)

Үүнд:

- 1 улиралд 3.6-с дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан 1 кр
- 2 улирал дараалан 3.6-с дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан 3 кр
- 3 улиралд дараалан 3.6-с дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан 5 кр

2.4 ШУТИС-ийн Оюутны холбооны удирдах зөвлөлийн гишүүд, оюутны байрны зөвлөлийн дарга болон гишүүд, бүрэлдэхүүн сургуулийн Оюутны зөвлөлийн дэд дарга, нарийн бичгийн дарга нарт ажлын үр дүнгээс хамааруулан сар бүр (1 ба 7 сард олгохгүй, 6 ба 8-р сард 50% хүртэл) урамшууллыг олгоно. Үүнд:

- Оюутны холбооны тэргүүн, дэд тэргүүн, ерөнхий нарийн бичгийн дарга 4 кр хүртэл
- Бүрэлдэхүүн сургуулийн оюутны зөвлөлийн дарга, гүйцэтгэх хорооны гишүүд 3 кр хүртэл
- Бүрэлдэхүүн сургуулиудын оюутны зөвлөлийн дэд дарга, нарийн бичгийн дарга, Оюутны байрны зөвлөлийн дарга 1 кр хүртэл
- Оюутны байрны зөвлөлийн гишүүдэд 0,5 кр хүртэл

Гурав. Урамшуулал олгох

3.1 Урамшуулалд хамрагдах оюутнуудын холбогдох бичиг баримтыг үндэслэн Оюутны холбоо, Нийгмийн технологийн сургууль (НТС) хамтран тодорхойлж, холбогдох проректор баталгаажуулснаар урамшуулал олгогдоно.

3.2 ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн захирлын нэрэмжит кредитийн урамшууллыг тухайн сургуулийн дэд захирал тодорхойлж, захирлын зөвлөлөөр хэлэлцэн баталгаажуулснаар улирал бүрийн эхэнд олгоно.

3.3 ШУТИС-ийн Оюутны холбооны удирдах зөвлөлийн гишүүд, оюутны байрны зөвлөлийн дарга болон гишүүд, бүрэлдэхүүн сургуулийн Оюутны зөвлөлийн дэд дарга, нарийн бичгийн дарга нарт урамшуулалыг дараах байдлаар олгоно. Үүнд:

3.3.1 ШУТИС-ийн Оюутны Холбооны тэргүүний урамшууллыг НТС-ийн захирлын тодорхойлолтыг үндэслэн Сургалтын проректор баталгаажуулснаар сард 1 удаа олгогдоно.

3.3.2 Оюутны Холбооны дэд тэргүүн, ерөнхий нарийн бичгийн дарга, гүйцэтгэх хорооны гишүүдийн урамшууллыг Оюутны Холбооны тэргүүний тодорхойлолтыг үндэслэн НТС-ийн захирал хянаж, Сургалтын проректор баталгаажуулснаар сард 1 удаа олгогдоно.

- 3.3.3 Бүрэлдэхүүн сургуулийн Оюутны зөвлөлийн дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга нарын урамшууллыг Оюутны Холбооны тэргүүний тодорхойлолтыг үндэслэн тухайн сургуулийн дэд захирал хянаж, захирал нь баталгаажуулснаар сард 1 удаа олгоно.
- 3.3.4 Оюутны байрны зөвлөлийн дарга, гишүүд нарын урамшууллыг Оюутны Холбооны тэргүүний тодорхойлтыг үндэслэн тухайн байрны эрхлэгч хянаж, холбогдох сургуулийн захирал баталгаажуулснаар сард 1 удаа олгоно.